

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

АЙМГУУДЫН ЗДТГ

2017 ОНЫ 1 ДҮГЭЭР САРД

Монгол Улсын 21 аймгийн Засаг даргын тамгын газар (ЗДТГ) Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаад орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд мониторинг хийж байна. Хуулиар нийтэд ил болгох ёстой мэдээллээс зургааг нь сонгон авч ЗДТГ-ууд 2017 оны 1 дүгээр сарын туршид тэдгээр мэдээллийг хэрхэн ил тод болгож байгааг ажиглав.

АЖИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ҮР ДҮН

2016 оны 12 дугаар сард 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ зөвхөн 1 аймаг л бүрэн мэдээлж байсан бол 2017 оны 1 дүгээр сард 5 аймаг 100 хувь нийтэлсэн ахиц гарчээ.

Энэ удаагийн мониторингоор Шилэн дансны тухай хууль (ШДХ)-ийн дагуу аймгуудын ЗДТГ 2017 оны 1 дүгээр сард ил тод болгосон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн тухайн сарын дансны хуулгатай харьцуулж үзэв (Тайлбар 2-ыг үзнэ үү).

100.0% Увс, Өвөрхангай, Орхон, Дорнод, Дархан-Уул

87.5% Дорноговь

83.3% Говьсүмбэр

71.4% Ховд

66.7% Хөвсгөл

50.0% Сэлэнгэ

42.9% Төв

40.0% Завхан, Дундговь, Баянхонгор

37.5% Өмнөговь

33.3% Хэнтий

20.0% Булган, Баян-Өлгий

16.7% Говь-Алтай, Архангай

0.0% Сүхбаатар

Тайлбар: 1 = 10%

ЦАЛИНГААС БУСАД 5 САЯ ТӨГРӨГӨӨС ДЭЭШ ҮНИЙН ДҮН БҮХИЙ ОРЛОГО, ЗАРЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

Нийт гүйлгээний тоо

11 Увс

7 Орхон, Дорноговь, Дархан-Уул

5 Хөвсгөл, Ховд, Өвөрхангай, Говьсүмбэр

4 Сэлэнгэ

3 Төв, Өмнөговь

2 Хэнтий, Завхан, Дундговь, Дорнод, Баянхонгор

1 Говь-Алтай, Булган, Баян-Өлгий, Архангай

0 Сүхбаатар

ШДХ-ийн 6.4.5-р заалтын дагуу цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг нийт 20 аймгийн ЗДТГ нийтэлжээ (Тайлбар 1-ийг үзнэ үү). Увс аймгийн ЗДТГ хамгийн олон буюу 11 мэдээлэл нийтэлсэн бол Сүхбаатар аймгийн ЗДТГ огт нийтлээгүй байна.

Тайлбар: 1 = 1 мэдээлэл

Гүйлгээнд холбогдох шийдвэрийн тоо

3 Төв

2 Өмнөговь, Завхан

0 Бусад

Зөвхөн гурван ЗДТГ цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээний шийдвэрээ нийтэлжээ.

Худалдан авалтын мэдээллийн тоо

2 Ховд

1 Өвөрхангай, Хөвсгөл, Завхан

0 Бусад

ШДХ-ийн 6.4.4-р заалтын дагуу 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалтын мэдээллийг 21 аймгийн ЗДТГ-аас 4 нь нийтэлжээ (Тайлбар 1-ийг үзнэ үү). Мэдээлэл нийтлээгүй зарим ЗДТГ "тухайн сард 5 саяас дээш төгрөгийн худалдан авалт хийгдээгүй" гэсэн тайлбар өгчээ.

24%



Хуулийн дагуу 1 дүгээр сарын 10-ны дотор нийтэд ил тод болгох ёстой тухайн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг зөвхөн 5 аймгийн ЗДТГ (Дархан-Уул, Завхан, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл) нийтэлжээ.

Нийт 21 аймгийн ЗДТГ 2017 оны батлагдсан төсвөө 1 дүгээр сарын 10-ны дотор буюу хуулийн хугацаанд нь ил тод болгожээ. Харин төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг Баян-Өлгийгөөс бусад аймгийн ЗДТГ хуулийн хугацаанд нь буюу 2 дугаар сарын 8-ны дотор ил тод нийтэлжээ.

Дүн мэдээнд хамаарах тайлбар:

- 5 сая төгрөгөөс дээш дүнтэй худалдан авалт болон гүйлгээний тоог гаргахдаа ЗДТГ-ын шилэн дансанд нийтлэгдсэн мэдээллээс зөвхөн үүнд хамааралтайг түүвэрлэж авсан болно.
- Төрийн сангийн гүйлгээнээс ил тод болгосон хувийг үнэлэхдээ зөвхөн энэ оны 1 дүгээр сард хамаарах 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт болон гүйлгээг тооцсон болно.

АШИГЛАСАН МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
- ЗДТГ-ын цахим хуудас
- ЗДТГ-ын мэдээллийн самбар
- Сангийн яамны Төрийн сангийн дансны хуулга

Орон нутаг дахь шилэн дансны хуулийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагууд мониторинг хийж дүнг сар бүр мэдээлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.